

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Равжаа	Дугаар	L193
Оршин суугаа аймаг	Ховд	Оршин суугаа сум	Булган сум
Төрсөн газар	Булган сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Хошуутын хийд	Сүм хийдийн дугаар	ХОБГ 096
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сар	Ярилцлага авсан хүн	С.Билэг-Өрнөх



Ховд аймгийн Булган сумын Хошуутын хийд

Равжаа: Яг энэ Хар уулын цаана Дөрөө хавчиг гэдэг юм. Тэрүүгээр даваад цааш орохлээр Харгант гэдэг газар байдаг юм. Харгантад Хошуутын хүрээ байсан юм. Харгантын тэр хар уулын ёроолд одоо ч хүрээгийн буурь суурь байна л даа. Айлуудын хадлан тал өвөлжчихсэн. За тэрүүн дээр хүрээ болвол гэртэй байсан юм. Одоо ингээд гэр, би ч одоо тэр 5, 6-тай майдар энэ тэр юм үзээд байж байхдаа тэр хүрээгийн байдлыг ажигласан л даа. Багадаа их ажиглаж байж, одоо бодоход. Тэгээд тэр нэг өдөр, нэг хавар цаг цагаан сар хийсний дараа майдар зална гэдэг байсан. Тэр майдар залахад бид нар аав ээжээ дагаад л очно. За тэгэхлээр лам нар, лам айлд очихлээр зэрэг их л цэвэр цэмцгэр байдаг юм байна лээ. Айл гэртээ нэг бандитай. Хоёр ч бандитай байдаг юм уу, нэг лам байдаг. Тэгээд л одоо төрөл садан ах дүү, таньдаг улсуудынхаа юугаар ороод тэгээд л одоо бид хүүхэд юм чинь боов энэ тэрээс нь амсаад л бариад л ингээд л. Тэр майдар залахлээр яадаг юм гэхлээр ийм одоо тэр бурхан шүтээнээ байна ш дээ, одоо ийм их модон дээр зална аа. Өчнөөн өндөр юм залчихсан байна.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

За тэгээд тэр дөрвөн хүн нь ийм юман дээрээ тавьчихаад, одоо маш их хүнд юм л яана. Эхлээд дээр их хүмүүсүүд цуглаад суучихсан байна. За тэгээд майдраа залаад ингэхээр улсууд одоо дор бүрнээ мөргөөд, тэр залж яваа майдар бурхны доогуур ингээд мөргөөд, би бас аав ээжээ дагаад ингээд мөргөөд. Тэгээд мөргөөд гарахлээр зэрэг шавь банди нар ийм том том судар барьчихсан, их том том судар ном баадантай. Тэгээд адислаад, жүжиг үзээд хүмүүсүүд тойроод суучихсан байна. Энд одоо цам цамнадаг юм гэнэ ээ. Тэгээд хамгийн гол дунд энэ цагаан өвгөн сууж байна. Тэр цамын цагаан өвгөн, овоо их урт сахалтай баг өмсчихсөн. Их ээ том шар царайтай, барын арьс ингээд дээлэн дээрээ тохчихсон тийм хүн сууж байна. Тэр цагаан өвгөнд л хөгшчүүл очоод л хадаг бариад л, дандаа хадагтай ингээд л мэндлээд байх юм. Тэр хадгийг нь аваад л мэндлээд л тэр цагаан өвгөн бүх улсуудтай нь мэндэлнэ ээ. Шар Азар, хар азар гэсэн хоёр азар. Дөрвөн хохимой бас одоо эрвээхэй гэсэн одоо энэ манай хүүхдийн юу шиг, хохимой байна, эрвээхэй байна. Азар байна, шар азар, хар азар. Буга байна, буга согоо тийм юмнууд тоглодог юм даа. Тэгээд за тэр их өвгөнөө, тэр бурхнаа юунууд гарч ирж тоглолт үзүүлж байна, улсууд. За тэр тоглолт үзүүлэхээр яах вэ гэхээр азар гараад ирэхлээр л одоо бас багтай юм, нэг аймаг багтай. Шар толгойтой, хар толгойтой тэр азар гараад ирэхлээр яг могой гартаа барьчихсан гараад ирж байгаа юм. Тэгээд одоо тэр хоёр азар яаж тоглож байна гэхээр, тоглоод дараа нь одоо тэр өвгөнийг, их амьтан л даа, тэр. Тэгээд буга согоонууд тоглож байна, бас. Өөрөөр хэлбэл бүжиглэж л байна л даа. Тэгээд буга ямар янзтай бүжиглэдэг юм. Хохимой гэдэг нь хүний хувхай гавал байна ш дээ, тэрүүн шиг баг хийчихсэн хохимой толгой гэж ярьдаг ш дээ. Хохимой багтай банди нар л тоглодог юм байлгүй. Эрвээхэй гэдэг юм бүжиглэнэ ээ. Иймэрхүү тоглолт хийгээд за энэ зүүн талд тоглосон бол өмнө зүгт очиж тоглоно оо гээд л өнөөхөө давтаад тоглоод байна. Тэгээд дөрвөн зүгтээ тоглоод байж байтал нар нь ороод бүр орой болох юм. Тэр тоглолтын зайгаар лам нар цайлна. Тэр хүрээнд гэхэд том оо одоо их том манз гэж хэлдэг юм даа. Том тогоо, тэрүүгээр дүүрэн хоол хийчихсэн. Тэр домботой цайнууд банди нар хүрч ирээд л тэр ном уншиж байгаа лам нарт цай хийж цайлаад, ардууд бас тэр дээгүүр нь цай уугаад ингээд л одоо нэг өдөржин л тэгж тоглодог байсан. Нэг өдөр л тэгж тоглоод майдар болж байна гэдэг. Тэгээд тэр бурхан шүтээнээ байрлуулаад тэр бурхан гэдэг тэгэхэд чинь одоо лам нар нүүдэг байсан, нүүнэ ш дээ. Тэгэхдээ бурхан бас морин дээр залж явдаг, тийм бурхантай байсан. За майдар тиймэрхүү байдалтай. Тэгээд бид нар тэр Харгантын ус юм байна л даа. Одоо хуурай болчихож гол урсаж байсан юм. Тэгээд тэрийг ажиглахаар энэ усан дотор тохой шахуу, нэг хэдэн төө гурвалжин, дөрвөлжин балин гээд юм хийчихсэн байна. Тэгээд би гайхах дээр тэр янз бүрийн будагтай юм усанд хаяихсан. Тэрэн дотор балин хаячихсан байна аа л гэж байна. Тэр усаа шүтэж байгаа юм уу, тахиж юм уу мэдэхгүй. Тиймэрхүү юм байсан юм, тэр Харганатад. Одоо бараг тийм шанд, булаг шахуу байв уу үгүй юу. Сахиусны жас гэж байсан юм. Тэгээд тэр сахиусны жас бол сахиус бурхантай байсан юм уу, ямар бурхан.

Билэг-Өрнөх: Мамба?

Равжаа: Жас, дүйнхорын жас гээд одоо нэртэй.

Билэг-Өрнөх: Хэдэн он хүртлээ?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Равжаа: 1937 он хүртэл байсан. Гучин долоон онд хүрээ тарлаа. Нэг мэдэхэд, би одоо бага сургуульд ороогүй хүүхэд байсан. Нэг мэдэхэд хүрээ лам нар, хүрээ тарж байна аа гэнэ. Хэд хэдэн эсэргүү лам баригдаж байна аа гэнэ. Ингээд улсууд шуугиад байна. Мухрын ёс дэлгэрч байна аа гэнэ, мухрын ёс. Үгүй тэгээд ямар юм гэж, том хүний ярианд хүүхдүүд сонссогодоггүй байсан юм ш дээ.Тэгээд гадуур дотуур багшийн ярьж байгаа юмыг сонсохлээр тэгж байна. Тэгээд нэг Луурай гэдэг ламтай хэдэн лам Ховдын Шар сүмд очиж яасан юм байна. Хурал цуглаан болсон юм байна, лам нарын.Тэр хүн шавь нараа авчирсан байсан юм байна. Тэгээд одоо хэдэн лам нараа цуглуулаад лам нартаа одоо ийм юм болж байна аа. Одоо энэ мухрын ёс нээгдэх юм гэнэ. Лам нар хүрээ хийдээ их анхааралтай бай гэсэн юм уу одоо, бараг бүү зэвсэг болгосон юм гэдэг. Хэн билээ, аймгийн дарга тэр үед. Тэр дарга бас тэрэнтэй холбоотой байж. Тэр нэг үгээр хэлэхэд эсэргүү юм байна л даа. Тэгээд л одоо лам нар ингээд бүү зэвсэгтэй болдог юм гэнэ ээ.Одоо энэ баахан хувьсгалын эсрэг босох л юм зохион байгуулсан юм байна л даа, тэр аймгийн дарга тэр шашны томоохон л улсууд. Өөрөөр хэлбэл тэр гучин долоон оны үед хувьсгал үүсээд 7 жил болж гэнэ. Тэр чинь гучин долоон он биш ээ...Тэгээд Луурай, Лүйрэн, Дилхаа , Гэндэн, Цэгмид ингээд нэг 8 хүн баригдаад явлаа. Тэр найм одоо эсэргүү гээд баригдаад, лам нар.Одоо бурхан шүтээнээ хураажээ. Бурхан шүтээнээ хураагаад одоо яасан юм гэхлээр тэр ламын тэчнээн, тэчнээн юм гээд бичээд, бичээд бурхнуудыг хураагаад тэгээд бурхнуудыг нь, бурхан одоо тэр ямар юм байдаг юм. Судар ном бүх хэрэгтэй юмнуудыг нь хурааж аваад...Тэгээд тэрүүгээр яасан гэвэл энэ Дарвийн төв байна ш дээ. Энэ Шар үс руу аваачаад шатаасан юм гэж сонссон юм. Үгүй ээ нэг, 7 хоног гэнэ үү, хэдэн хоног асч дуусдаггүй.